




Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргаагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргаагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: Айтүүлс ХК УБГД: 9010001141 Үнэт цаасны код: 543 Утас: 75755585 Имэйл: info@itools.mn , secretary@itools.mn Фэйсбүүк: Айтүүлс ХК
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мэдээллийн технологи, харилцаа холбоо /Дата төвийн үйлчилгээ/
Үнэт цаас гаргаагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	34,452,124
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Нягтлан бодогч: Б.Өнөрбадрах Борлуулалтын мэргэжилтэн: ТУЗ-ийн н/б дарга: Г.Янжинлхам Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхжаргал
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Орлогын тайлан
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Мөнгөн гүйлгээний тайлан
2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Нэгдүгээр хавсралтаар хүргүүлэв.	

2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит хурлаар Айтүүлс ХК-ийн 2026 оны нэгдүгээр хагас жилийн тайланг хэлэлцэнэ.	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргаагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Цэвэр ашгийн хувь 6.2% Өөрийн хөрөнгийн өгөөж 3.6% Нийт хөрөнгийн өгөөж 3.2% Нэгж хувьцаанд ногдох ашиг 5.1 Эргэлтийн харьцаа 5.06 Түргэн хөрвөх чадварын харьцаа 4.54
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	
3.3.	Үнэт цаас гаргаагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Хавсралтаар хүргүүлэв.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
4.	Үнэт цаас гаргаагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	

	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i> Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр танхимаар амжилттай зохион байгуулж, хурлын тайлан болон холбогдох материалыг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын хөрөнгийн бирж (МХБ)-д хүргүүлээд байна. ТУЗ-ийн дэргэдэх хороодын зохион байгуулалт: Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийг удирдлага болгон ТУЗ-ийн 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн №26/010 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх чиг үүргийн 4 хороог шинээр байгуулж, дарга болон гишүүдийг томилов. Үүнд: • Нэр дэвшүүлэх хороо: Дарга Г.Гантуяа (хараат бус), гишүүд О.Мөнхзул (хараат бус), П.Дэлгэрмаа (ердийн); • Цалин, урамшууллын хороо: Дарга О.Мөнхзул (хараат бус), гишүүд Б.Жавхланбаяр (хараат бус), Г.Хатанболд (ердийн); • Аудит, мэдээллийн аюулгүй байдлын хороо: Дарга О.Мөнхзул (хараат бус), гишүүд Г.Гантуяа (хараат бус), В.Болорчимэг (ердийн); • Бизнес хөгжлийн хороо: Дарга З.Төрболд (хараат бус), гишүүд А.Баттамир (ердийн), Ч.Мөнхжаргал (ердийн). Хороодыг хараат бус гишүүдээр ахлуулсан нь ТУЗ-ийн шийдвэр гаргалт, хяналтын процессыг илүү хараат бус, мэргэжлийн түвшинд явуулах засаглалын давуу талыг бий болгож байна. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга: Компанийн засаглалын кодексийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс ТУЗ-өөс баталсан дүрэм, журам, зааврын биелэлтийг хангуулан ажиллалаа. ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын бэлтгэл зохион байгуулалтыг хангаж, хурлаас гарах шийдвэрийн төслийг боловсруулах, ТУЗ-ийн гишүүдээс хэлэлцэх асуудлын мэдээлэл, баримт материалыг цаг тухай бүрт хүргэх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлэн ажиллав.
6.	<i>Үнэт цаас гаргаагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i> Компанийн 2026 оны хоёрдугаар улирлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх ээлжит хурлыг 8 дугаар сарын 10-ны өдөр хийхээр төлөвлөн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Засаглалын үнэлгээ ба сайжруулалт: Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн явцыг дотооддоо үнэлж, "Компанийн засаглалын үнэлгээний тайлан"-г тогтоосон хугацаанд зааврын дагуу боловсруулан Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж хэвшсэн. Цаашид уг үнэлгээний дүн болон ирүүлсэн зөвлөмжид үндэслэн засаглалыг тасралтгүй сайжруулах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу авч ажиллахаар төлөвлөж байна.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Чимэдхишигийн Мөнхжаргал Албан тушаал: "Айтүүлс" ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг:  (Тамга/тэмдэг) 	Овог, нэр: Албан тушаал: "....." ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Г.Янжинлхам Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Гарын үсэг: 	



2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны 06 сарын 30



2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

> *Айтүүлс ХК-ийн 15 жилийн ой тохиож байна*



2011 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр үүсгэн байгуулагдсан Айтүүлс ХК (анх Интеллежент Түүлс ХХК нэртэйгээр) программ хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн билээ. Айтүүлс ХК байгуулагдсанаасаа хойш дижитал шилжилтийг дэмжих, технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр тасралтгүй хөгжиж, өнөөдөр салбартаа тэргүүлэгч байгууллагуудын нэг болон өргөжин тэлжээ.

15 жилийн хугацаанд Айтүүлс ХК нь “дижитал орчны үнэ цэнийг хүчирхэгжүүлэх найдвартай суурь нь байх” эрхэм зорилгын хүрээнд олон улсын стандартад нийцсэн дата төвийг байгуулж, найдвартай дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдал, технологийн цогц шийдлүүдийг харилцагч, хэрэглэгчдэдээ амжилттай хүргэсээр ирсэн байна.

Компанийн амжилтын үндэс нь үнэнч, хариуцлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай, бүтээлч хамт олон бөгөөд тэдний хүчин чармайлтын үр дүнд Айтүүлс ХК нь шинийг санаачлагч, салбартаа манлайлагч байгууллага болон хөгжсөөр байна.

Өнгөрсөн хугацаанд хамтран ажилласан хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид,

харилцагчид болон бизнесийн түншүүдийн итгэл, дэмжлэг нь компанийн өсөлт, хөгжлийн гол тулгуур болж ирсэн юм. Энэхүү итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурлан Айтүүлс ХК нь ирээдүйн илүү том зорилтуудыг тодорхойлон, дижитал үнэ цэнийг улам бүр нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

Айтүүлс ХК-ийн 15 жилийн ойн хүрээнд компанийн хамт олны зүгээс нийт хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түнш байгууллагууддаа гүн талархал илэрхийлж, цаашдын хөгжил дэвшил, тогтвортой өсөлт, хязгааргүй боломжийг хүсэн ерөөж байна.

> *Айтүүлс ХК Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа амжилттай зохион байгууллаа*



“Айтүүлс” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Континентал зочид буудал”-д амжилттай зохион байгуулагдлаа. Хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 51.94% нь оролцсоноор Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1 дэх хэсэгт заасны дагуу хурлын ирц бүрдэн, дараах асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

- Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Ч. Мөнхжаргал танилцууллаа.

2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Техникийн үйл ажиллагааны хэлтсийн менежер, Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн Ч. Гансүлд “Мэдээллийн аюулгүй байдлыг онцлох нь” сэдвийн хүрээнд илтгэлийг танилцууллаа.
- Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг Юнистар аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Энхжаргал танилцууллаа.
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлалаа.
- ТУЗ-өөс нэгж хувьцаанд 4 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэв.
- Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцууллаа.
- Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг сонголоо.
- Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг баталлаа.

Ийнхүү Айтүүлс ХК нь 2025 оны үйл ажиллагааны үр дүнгээ дүгнэж, цаашдын стратеги, төлөвлөгөөгөө тодорхойлон, компанийн засаглалын ил тод байдал, хувьцаа эзэмшигчдийн оролцоог ханган амжилттайгаар ээлжит хурлаа зохион байгууллаа.

> Олон улсын ISO/IEC 27001:2022 болон ISO 9001:2015 стандартын шилжилт, баталгаажуулалт амжилттай хийгдлээ

“Айтүүлс ХК” мэдээллийн аюулгүй байдал болон чанарын удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулах зорилгын хүрээнд олон улсын стандартуудын шилжилт болон дахин баталгаажуулалтыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Тодруулбал, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандарт болох ISO/IEC 27001:2013 хувилбараас ISO/IEC 27001:2022 шинэ хувилбар луу амжилттай шилжлээ. Энэхүү шинэчлэл нь кибер аюулгүй байдлын орчин үеийн эрсдэл, шаардлагад нийцсэн, илүү уян хатан, үр ашигтай хяналтын арга хэмжээнүүдийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Мөн чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг дахин баталгаажуулж, байгууллагын үйл ажиллагаа олон улсын шаардлагад нийцэж, тасралтгүй сайжирч байгааг харуулж байна.

Эдгээр стандартуудыг амжилттай хэрэгжүүлж, баталгаажуулснаар:

- Харилцагч, хэрэглэгчдийн мэдээллийн аюулгүй байдал илүү найдвартай хамгаалагдана
- Үйлчилгээний чанар, процессын тогтвортой байдал нэмэгдэнэ
- Олон улсын түвшинд өрсөлдөх чадвар улам бэхэжнэ

Цаашид манай байгууллага олон улсын шаардлагыг тасралтгүй үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, харилцагчдын итгэлийг эрхэмлэн ажиллах болно.



2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

> *Айтүүлс ХК Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийн мөнгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” рүү шилжүүллээ.*

“Айтүүлс” ХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн № 26/002 тоот тогтоолын дагуу бүх хувьцаа эзэмшигчдийн татвар суутгасны дараах ногдол ашгийг нэгдсэн дүнгээр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК руу 2026 оны 4-р сарын 29-ний өдөр шилжүүллээ.




> *Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан “Маркетингийн зөвлөгөө өгөх өдөрлөг”-ийн ивээн тэтгэгчээр оролцлоо*

Өдөрлөгийн хүрээнд Айтүүлс ХК-ийн Маркетинг, борлуулалтын ахлах мэргэжилтэн Т. Энхмаа “Жижиг, дунд бизнесийн өсөлтөд дижитал шилжилтийн үүрэг” сэдвээр илтгэл тавьж, бизнесийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дижитал шилжилтийн ач холбогдол, бодит хэрэглээ, туршлагын талаар мэдээлэл хүргэлээ. Мөн оролцогчдод Sitejet Web Builder платформыг танилцуулж, программчлалын мэдлэг шаардалгүйгээр мэргэжлийн вебсайтыг хялбар, хурдан бүтээх боломж, ашиглах аргачлалын талаар практик зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан юм.



ШИНЭ БОЛОМЖУУД

> Sitejet Webbuilder Монгол хэлээр...



Айтүүлс ХК нь cPanel-ийн албан ёсны борлуулагч бөгөөд хостингийн орчинд ашиглагдах шийдлүүдийг хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй болгох чиглэлд тогтмол хөгжүүлэлт хийж ажилладаг. Айтүүлс ХК-ийн инженерүүд Sitejet Builder платформд Монгол хэлний хэрэглээг нэвтрүүлж, хэрэглэгчид Монгол интерфэйсээр ашиглах боломжийг нээлээ.

> Sitejet Webbuilder



Вебсайт бүтээх салбарт сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаан болон no-code шийдлүүд эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд энэ чиг хандлагын нэг тод жишээ нь SITEJET BUILDER юм.

Sitejet нь онлайн орчинд вебсайт хийх, засварлах, нийтлэх боломж бүхий контент удирдлагын систем (CMS) бөгөөд хэрэглэгчид код бичих шаардлагагүйгээр бэлэн загвар, визуал editor болон хиймэл оюуны тусламжтайгаар мэргэжлийн веб сайт бүтээх боломжийг олгоно.

Sitejet Webbuilder турших

> Next generation firewall (NGFW) сүлжээний аюулгүй байдлын систем амжилттай нэвтрүүлээ

itools

FORTINET

NEXT GENERATION FIREWALL

АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЛЭЭ

Next Generation Firewall (NGFW) нь уламжлалт сүлжээний хамгаалалтаас давсан боломжуудыг нэгтгэсэн дэвшилтэт хамгаалалтын шийдэл юм. Сүлжээний урсгалыг хянахаас гадна мэдээллийн агуулгад шинжилгээ хийж, хэрэглэгчийн хандалтыг удирдах, вирус, malware, ransomware зэрэг кибер аюулыг бодит цаг хугацаанд илрүүлэн таслан зогсоох боломжийг олгодог.

Айтүүлс ХК нь дэлхийн кибер аюулгүй байдлын салбарын тэргүүлэгч Fortinet брэндийн Next Generation Firewall (NGFW) шийдлийг албан ёсоор нэвтрүүлж, байгууллагын сүлжээ, өгөгдөл болон дижитал орчныг олон улсын түвшний хамгаалалтаар хангаж байна.

ШИНЭ БОЛОМЖУУД

> Веб байршуулах үйлчилгээ шинэчлэгдлээ

ВЕБ БАЙРШУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ШИНЭЧЛЭГДЛЭЭ

IMUNIFY 360 хамгаалалт ✓ Firewall, IDS/IPS ✓ Хортой код илрүүлэлт ✓ Malware scanning 	NVMe hard ✓ 3 дахин хурдан ✓ Олон үйлдэл боловсруулах ✓ Бага хоцрогдол 	
---	---	--

Хэрэглэгчдэд илүү хурдан, найдвартай, ашиглахад хялбар орчныг бүрдүүлэх зорилгоор манай веб байршуулах үйлчилгээ дараах томоохон шинэчлэлүүдийг амжилттай нэвтрүүллээ.

- **Илүү хурд, илүү тогтвортой ажиллагаа - NVMe диск** нь уламжлалт SSD-ээс хэд дахин хурдан ажиллах бөгөөд дараах үндсэн давуу талуудтай:
 - Веб сайтын ачааллыг багасгана
 - Өгөгдөл боловсруулалтыг сайжруулна
 - Ачаалал өндөр үед ч тасалдалгүй, тогтвортой ажиллагааг хангана
 - Таны бизнес өсөхийн хэрээр вебсайт тань ч нэмэгдэж буй ачааллыг төвөггүй даах болно.
- **Дэвшилтэт хамгаалалт - Imunify360** нь Linux веб сервер болон хостинг орчинд зориулсан ухаалаг хамгаалалтын систем бөгөөд дараах үндсэн боломжуудтай:
 - Malware болон хорт кодыг автоматаар илрүүлж цэвэрлэнэ
 - DDoS, Brute Force оролдлогуудыг блок хийнэ
 - Веб халдлагыг блок хийх Web Application Firewall (WAF)
 - Сэжигтэй үйлдэл, халдлагыг илрүүлж зогсоох Intrusion Detection & Prevention системтэй
 - Серверийн аюулгүй байдлыг 24/7 хянадаг учраас таны Веб сайтын тогтвортой, найдвартай ажиллагааг дэмжинэ.
- **Код бичихгүйгээр веб сайт бүтээх боломж - Sitejet Webbuilder** нь онлайн орчинд вебсайт хийх, засварлах, нийтлэх боломж бүхий контент удирдлагын систем (CMS) бөгөөд хэрэглэгчид код бичих шаардлагагүйгээр бэлэн загвар, визуал editor болон хиймэл оюуны тусламжтайгаар мэргэжлийн вебсайт бүтээх боломжийг олгоно.
 - Drag-and-drop editor
 - AI сайтаар бүтээх технологи
 - 120+ Бэлэн загвар
 - Контент удирдлага (CMS)
 - SEO ба гүйцэтгэл

Та Айтүүлс ХК-н 1 домэйн болон олон домэйн хост үйлчилгээг авснаар Sitejet builder платформ-г Монгол интерфэйсээр ашиглан өөрийн бизнесийн онцлогт тохирсон вебсайтыг бүтээгээрэй.

ОНЦЛОХ МЭДЭЭЛЭЛ

> SSL үйлчилгээ хэрэглэгчдийн анхааралд! Сертификатын шинэчлэх хугацаа 200 хоног боллоо



Олон улсын SSL/TLS сертификатын шаардлагыг тодорхойлогч Сертификат олгогч байгууллагууд болон браузер хөгжүүлэгчдийн форум (CA/Browser Forum)-ын шийдвэрийн дагуу 2026 оны 3 дугаар сарын 15-наас эхлэн нийтийн SSL/TLS сертификатын шинэчлэх хугацаа 398 хоногоос 200 хоног болж өөрчлөгдлөө.

Тус форум нь дэлхийн томоохон браузер хөгжүүлэгчид болон сертификат олгогч байгууллагуудыг нэгтгэсэн олон улсын байгууллага бөгөөд интернэтийн аюулгүй байдлын нийтлэг шаардлагыг тогтоодог.

Яагаад шинэчлэх хугацаа багассан бэ?

Энэхүү өөрчлөлтийг дараах бодит шалтгаануудтай холбоотойгоор хийж байна:

1. Кибер халдлагын эрсдэл нэмэгдэж байна

Хэрэв SSL сертификаттай холбоотой нууц түлхүүр алдагдвал тухайн сертификатыг ашиглан хуурамч сайт ажиллуулах, мэдээлэл дундаас нь унших зэрэг эрсдэл үүсдэг. Хугацаа урт байх тусам ийм эрсдэл удаан хугацаанд үргэлжилдэг тул шинэчлэх хугацааг богиносгож байна.

2. Ирээдүйн технологийн нөлөө (квант компьютер)

Квант компьютер хөгжихийн хэрээр одоогийн шифрлэлтийн зарим аргууд тайлагдах өндөр магадлалтай гэж үзэж байгаа ба үүнээс шалтгаалан сертификатын хугацааг богино байлгах нь урьдчилан сэргийлэх, эрсдэлийг багасгах нэг арга юм.

3. Домэйн болон байгууллагын мэдээллийг илүү ойр хугацаанд баталгаажуулах шаардлага нэмэгдсэн

Байгууллагын нэр, эзэмшигч, домэйн нэрийн эрх зэрэг мэдээлэл өөрчлөгдсөн ч сертификат удаан хугацаанд хүчинтэй байвал хуучин мэдээлэл хэрэглэгчдэд харагдсаар байх эрсдэлтэй. Богино хугацаа нь энэ мэдээллийг илүү ойр ойрхон шалгах боломж бүрдүүлж байна.

Шинэчлэх хугацааны өөрчлөлтийн хуваарь

- 2026 он – 200 хоног
- 2027 он – 100 хоног
- 2029 он – 47 хоног

Төлбөрийн нөхцөл өөрчлөгдсөн үү?

Төлбөрийн нөхцөл өөрчлөгдөөгүй. Зөвхөн сертификатыг 200 хоног тутамд шинэчлэн тохируулга хийх шаардлагатай болжээ.

АЙТҮҮЛС ХК нь хэрэглэгч та бүхнийг энэхүү өөрчлөлтөд бэлтгэж, үйлчилгээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангахыг зөвлөж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ШИНЖИЛГЭЭ

2026 оны эхний хагас жилийн **Санхүү байдлын тайлан** /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2025 оны 12-р сарын 31	2026 оны 06-р сарын 30
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	629,833	646,378
Дансны авлага	1,717,107	1,941,069
Татвар, НДШ-ийн авлага	0	0
Бусад авлага	142,877	116,194
Бусад санхүүгийн хөрөнгө	0	0
Бараа материал	12,175	12,175
Урьдчилж төлсөн зардал тооцоо	17,297	162,590
Бусад эргэлтийн хөрөнгө	0	0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0	0
...		
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,519,289	2,878,406
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	3,033,056	2,749,267
Биет бус хөрөнгө	12,550	9,541
Биологийн хөрөнгө	0	0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	80,446	80,446
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0	0
Хойшлогдсон татварын хөрөнгө	0	0
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх	0	0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	0	0
...	0	0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,126,052	2,839,254
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,645,341	5,717,660
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	246,695	251,081
Цалингийн өглөг	0	30,848
Татварын өр	84,172	76,747
НДШ-ийн өглөг	0	0
Богино хугацаат зээл	0	0
Хүүний өглөг	0	0
Ногдол ашгийн өглөг	0	0
Урьдчилж орсон орлого	202,375	210,684
Нөөц / өр төлбөр /	0	0
Бусад богино хугацаат өр төлбөр	0	0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0	0
...	0	0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	533,242	569,360
Урт хугацаат өр төлбөр	0	0
Урт хугацаат зээл	0	0
Нөөц / өр төлбөр/	0	0
Хойшлогдсон татварын өр	0	0
Бусад урт хугацаат өр төлбөр	0	0
...	0	0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0	0
Өр төлбөрийн нийт дүн	533,242	569,360

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ШИНЖИЛГЭЭ

Эздийн өмч	0	0
Төрийн өмч	0	0
Хувийн өмч	1,481,441	1,481,441
Хувьцаат	0	0
Халаасны хувьцаа	0	0
Нэмж төлөгдсөн капитал	763,114	763,114
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	588,542	588,542
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0	0
Эздийн өмчийн бусад хэсэг	0	0
Хуримтлагдсан ашиг	2,279,001	2,315,201
...	0	0
Эздийн өмчийн дүн	5,112,098	5,148,298
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	5,645,340	5,717,658

2026 оны эхний хагас жилийн **Орлогын дэлгэрэнгүй тайлан** /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2025 оны 12-р сарын 31	2026 оны 06-р сарын 30
Борлуулалтын орлого (цэвэр)	5,631,490	2,805,258
Борлуулалтын өртөг	3,630,200	2,069,022
Нийт ашиг (алдагдал)	2,001,290	736,236
Түрээсийн орлого	41,091	20,682
Хүүгийн орлого	40,713	40,832
Ногдол ашгийн орлого	0	0
Эрхийн шимтгэлийн орлого	0	0
Бусад орлого	10,285	2,564
Борлуулалт, маркетингийн зардал	244,756	151,898
Ерөнхий ба удирдлагын зардал	608,294	450,935
Санхүүгийн зардал	8,770	0
Бусад зардал	408,314	1,980
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,006	5
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-2,645	-1,943
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0	0
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0	0
Бусад ашиг (алдагдал)	0	0
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	824,605	193,563
Орлогын татварын зардал	81,892	19,554
Татварын дараах ашиг (алдагдал)	742,713	174,009
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	742,713	174,009
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	742,713	174,009
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	21.6	5.1

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ШИНЖИЛГЭЭ

2026 оны эхний хагас жилийн **Мөнгөн урсгалын тайлан** /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2025 оны 12-р сарын 31	2026 оны 06-р сарын 30
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	4,948,691	2,845,654
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	4,923,243	2,827,064
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	25,448	18,590
Мөнгөн зарлагын дүн (-)	4,366,584	2,607,617
Ажиллагчдад төлсөн	932,928	522,222
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	258,976	157,111
Бараа материал худалдан авахад төлсөн	2,070,154	1,412,981
Ашиглалтын зардалд төлсөн	245,421	119,413
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг	2,738	1,000
Хүүний төлбөрт төлсөн	0	0
Татварын байгууллагад төлсөн	629,226	281,424
Даатгалын төлбөрт төлсөн	3,657	4,175
Бусад мөнгөн зарлага	223,484	109,291
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	582,108	238,037
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн		
Мөнгөн орлогын дүн (+)	435,552	55,742
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	9,450	
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0	
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0	
Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны	387,147	24,000
Хүлээн авсан хүүний орлого	38,955	31,742
Хүлээн авсан ногдол ашиг	0	0
Мөнгөн зарлагын дүн (-)	582,984	216,404
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	162,984	122,404
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	0
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд		0
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	420,000	94,000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр	-147,433	-160,662
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	0	
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн		0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас	0	0
Төрөл бүрийн хандив	0	0
Мөнгөн зарлагын дүн (-)	227,612	60,835
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	138,500	0
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0	0
Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0	0
Төлсөн ногдол ашиг	89,112	60,835
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-227,612	-60,835
Валютын ханшийн зөрүү	4,152	4.81
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	211,216	16,545
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	418,618	629,834
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	629,834	646,378

■ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ШИНЖИЛГЭЭ

2026 оны эхний хагас жилийн **Өмчийн өөрчлөлтийн тайлан** /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлт	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0	0	0
Залруулсан үлдэгдэл	1,481,441	0	763,115	460,722	0	0	1,656,872	4,362,150
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0	0	0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	0	0	742,713	742,713
Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0	0	0	0	0
Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0	0	120,582	120,582
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	127,821	0	0	0	0
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441	0	763,115	588,543	0	0	2,279,002	5,112,101
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0	0	0
Залруулсан үлдэгдэл	1,481,441	0	763,115	588,543	0	0	2,279,002	5,112,101
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0	0	0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	0	0	174,009	174,009
Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0	0	0	0	0
Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0	0	137,808	137,808
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0	0	0
2026 оны 06-р сарын 30-ний үлдэгдэл	1,481,441	0	763,115	588,543	0	0	2,315,202	5,148,301

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХЭРХЭН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

> Байгууллагын ажилтнууд

2026 онд ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэхээр дотоод болон гадаад эх үүсвэрүүдээс нийт 14 төрлийн сургалтыг зохион байгууллаа. Үүнээс бүх ажилтныг хамарсан 10 сургалт, мэргэшүүлэн сертификатжуулах 3 сургалтад 4 ажилчид амжилттай хамрагдсан байна.

> Хэрэглэгчид

Үйлчилгээний сайжруулалт

- Веб байршуулах үйлчилгээ

Хэрэглэгчдэд илүү хурдан, найдвартай, ашиглахад хялбар орчныг бүрдүүлэх зорилгоор манай веб байршуулах үйлчилгээ дараах томоохон шинэчлэлүүдийг амжилттай нэвтрүүллээ.

- Илүү хурд, илүү тогтвортой ажиллагаа – NVMe диск
- Дэвшилтэт хамгаалалт – Imunify360
- Код бичихгүйгээр веб сайт бүтээх боломж – Sitejet Webbuilder

- Next generation firewall (NGFW)

Firewall нь байгууллагын дотоод сүлжээг гаднын эрсдэлээс хамгаалж, зөвшөөрөлгүй хандалтыг хянах үндсэн хамгаалалтын үүргийг гүйцэтгэдэг. Харин сүүлийн жилүүдэд кибер халдлага илүү ухаалаг, далд, олон сувгаар зэрэг явагддаг болсон учраас байгууллагууд уламжлалт firewall-аас дараагийн үеийн буюу Next Generation Firewall (NGFW) технологид шилжлээ.

Урамшуулалт хөтөлбөр

- Antivirus plus /BAP50/ – Bitdefender antivirus plus вирусийн программыг 50 хувийн хөнгөлөлттэй ашиглах урамшуулал
- Мониторинг болон Нөөцлөлтийн үйлчилгээ /Monitoring100, Backup100/ – Таны сервер, системийн тасалдалгүй, найдвартай байдлыг хангах Мониторинг болон Нөөцлөлтийн үйлчилгээний эхний сарыг 100 хувь үнэ төлбөргүй ашиглах урамшуулал
- Веб байршуулах үйлчилгээ /itools15/ – Айтүүлс ХК-ийн 15 жилийн ойд зориулан бүх төрлийн веб байршуулах үйлчилгээний 15 хувийн хөнгөлөлттэй ашиглах урамшуулал
- Веб байршуулах үйлчилгээ /sitejet15/ – 1 болон олон домэинтэй веб байршуулах үйлчилгээний 15 хувийн хөнгөлөлттэй ашиглах урамшуулал зэрэг урамшуулалт хөтөлбөрүүдийг 2026 оны эхний хагас жилийн турш хэрэглэгчдэд санал болгон ажилласан байна.

> Хэрэглэгчийн мэдлэгт

Бид хэрэглэгчдийнхээ мэдлэгт зориулан технологийн чиг хандлага, тэр дундаа дата төвийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой танин мэдэхүйн блогуудыг тогтмол нийтэлдэг билээ. 2026 оны эхний хагас жилд 15 сэдвийн хүрээнд блог бэлтгэн нийтлээд байгаа юм. Та Айтүүлс ХК-н мэргэжлийн хамт олон бэлтгэн гаргадаг технологийн салбарын талаар сонирхолтой блогуудтай танилцахыг хүсвэл [ЭНД](#) дарна уу.

Мөн “Дижитал орчны эргэн тойронд” нэртэйгээр Айтүүлс ХК-ийн үйл ажиллагаа болон, технологийн салбарын эргэн тойронд болж буй үйл явдлын товхимлыг улирал тутамд хэрэглэгчдэд бэлтгэн илгээсэн байна.

> Хувьцаа эзэмшигчид

Айтүүлс ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Уг хурлаар:

- Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Ч. Мөнхжаргал танилцууллаа.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХЭРХЭН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

- Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг Юнистар аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Энхжаргал танилцууллаа.
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлалаа.
- ТУЗ-өөс нэгж хувьцаанд 4 (дөрвөн) төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, 2025 оны цэвэр ашгийн 18.55 (арван найм зууны тавин тав) хувийг буюу 137,808,496 (нэг зуун гучин долоон сая найман зуун найман мянга дөрвөн зуун ерэн зургаа) төгрөгийг Хувьцаа эзэмшигч нартаа мөнгөн хэлбэрээр 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр "ҮЦТХТ" ХХК-аар дамжуулан Хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа.
- Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга Г. Хатанболд танилцууллаа.
- Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, нийт Хувьцаа эзэмшигчдийн нээлттэй саналаар сонголоо.
- Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлалаа.

Компанийн зүгээс цаашид хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зорин ажиллах болно.

> Нийлүүлэгчид

Айтүүлс ХК нь дата төвийн тасалдалгүй найдвартай ажиллагааг 100% ханган бэлэн байдалд байлгахыг зорьдог. Ийм ч учраас бид салбар бүртээ тэргүүлэгч компаниудтай жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ийн бодлогын хэрэгжилт

Айтүүлс ХК нь мэдээллийн технологийн салбарын тэргүүлэгч байгууллагын хувьд тогтвортой хөгжлийг бизнесийн стратегийн салшгүй хэсэг болгон Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын зарчмуудыг үйл ажиллагаандаа үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжих, мэдээллийн аюулгүй байдал болон компанийн засаглалыг бэхжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлэв.

> Байгаль орчин (Environmental)



Мэдээллийн технологи, тэр дундаа Дата төвийн үйл ажиллагаа нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ өндөртэй байдаг тул компани байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад онцгой анхаарч байна.

- Эрчим хүчний үр ашиг ба ногоон технологи: Дата төвийн серверийн тоног төхөөрөмжүүдийн хөргөлтийн системийг орчин үеийн ухаалаг, эрчим хүчний хэмнэлттэй технологиор шинэчилж, нүүрстөрөгчийн ялгарлыг (Carbon footprint) багасгах алхмуудыг шат дараатай хэрэгжүүллээ.
- Цахим шилжилт: Компани дотоод үйл ажиллагаа болон харилцагчийн үйлчилгээгээ бүрэн цахимжуулснаар (үүнд цахим гэрээ, онлайн нэхэмжлэх, тоон гарын үсэг багтана) тайлант хугацаанд цаасны хэрэглээг үлэмж хэмжээгээр бууруулж, байгалийн нөөцийг хэмнэхэд хувь нэмэр орууллаа.

> Нийгмийн хариуцлага (Social)

Компани нь ажилтан бэлтгэх, хүний эрхийг дээдлэх, мэдээллийн аюулгүй байдал болон үйлчилгээний тасралтгүй чанарыг хангах замаар нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа хэрэгжүүлдэг.

- Хүйсийн тэгш эрхт байдал ба Хүний нөөцийн бодлого: Айтүүлс ХК нь хүний нөөцийн бодлогодоо хүйсийн тэгш эрхт байдлыг хангах, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих зарчмыг тууштай баримталдаг. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг эмэгтэй Гүйцэтгэх захирал удирдан чиглүүлж байгаа бөгөөд нийт ажилтнуудын 57% нь эрэгтэй, 43% нь эмэгтэй ажилтантайгаар хүйсийн тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж байна. Ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг чанд мөрдөж байна.
- Ажилтны оролцоо ба байгууллагын соёл: Компанийн 15 жилийн ойг тохиолдуулан ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, байгууллагын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, хамт олны уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор дотоод арга хэмжээнүүдийг зохион байгуулж, олон жил үр бүтээлтэй ажилласан болон онцлох амжилт гаргасан ажилтнуудыг шагнаан урамшууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)-ИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ



- Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандарт: Компани нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог 4 дэх жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд буюу 2026 оны 05 дугаар сард олон улсын ISO27001:2013 стандартаас шинэчлэгдсэн ISO27001:2022 стандартын шилжилтийг амжилттай хийж, мэдээллийн хамгаалалтын түвшнийг ахиуллаа. Энэхүү стандартын хүрээнд нийт ажилтнуудад Мэдээллийн аюулгүй байдлын сургалтыг тогтмол орж, дотоод соёлыг бэхжүүлж байна.
- Дата төвийн тасралтгүй ажиллагаа ба Найдвартай байдал: Айтүүлс ХК-ийн үндсэн Дата төвийн uptime буюу тасалдалгүй ажиллагааны үзүүлэлт 2026 оны эхний хагас жилд 100%-ийн гүйцэтгэлтэй байлаа. Компани нь эрсдэлийг удирдах, өгөгдлийг хамгаалах зорилгоор нөөц дата төвтэй ажилладаг бөгөөд тогтмол нөөцлөлт (backup) хийж, гамшгийн үеийн сэргээн босголтын төлөвлөгөөг (Disaster Recovery Plan) боловсруулан, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Харилцагчийн үйлчилгээ ба Сэтгэл ханамжийн үнэлгээ: Харилцагчдад 24/7 цагийн турш техникийн дэмжлэг, туслалцааг тасралтгүй үзүүлж байна. Үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор нийт хэрэглэгчид болон үйлчилгээ тус бүрээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа нэгдсэн байдлаар үнэлдэг. Мөн хэрэглэгчид өөрсдийн систем болон вэбсайтаар дамжуулан үйлчилгээний чанарт тухай бүр шууд үнэлгээ, санал хүсэлт өгөх боломжийг бүрэн нээж, эргэх холбоог сайжрууллаа.
- Хандивын үйл ажиллагаа: “Монголын Маркетингийн Холбоо”-ноос Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан “Маркетингийн зөвлөгөө өгөх өдөрлөг”-т ивээн тэтгэгч байгууллагаар хамтран ажиллаа. Энэхүү арга хэмжээ нь Улаанбаатар хот болон Эрдэнэт хотуудад зохион байгуулагдсан бөгөөд арга хэмжээний үеэр бизнесийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дижитал шилжилтийн ач холбогдол, бодит хэрэглээ, туршлагын талаар мэдээлэл хүргэлээ.



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)-ИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

> Компанийн засаглал (Governance)

Компанийн засаглалыг ил тод, хариуцлагатай, хөрөнгө оруулагчдад өгөөжтэй байдлаар хөтлөн явуулах нь БОНЗ-ийн бодлогын гол цөм юм.

- Ил тод, нээлттэй байдал: Олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд засаглалын ил тод байдлыг хангах зорилгоор үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, ТУЗ-ийн шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд цаг тухайд нь үнэн зөв мэдээлж хэвшлээ.
- ТУЗ-ийн бүтэц ба хүйсийн тэнцвэрт байдал: 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгон батламжилсан. Шинэчилсэн ТУЗ нь нийт 9 гишүүнтэй бөгөөд үүнээс 5 эмэгтэй, 4 эрэгтэй гишүүн сонгогдсон нь компанийн шийдвэр гаргах дээд түвшинд хүйсийн тэнцвэртэй байдлыг маш сайн хангаж, засаглалын дэвшилтэт соёлыг бүрдүүлснийг илтгэж байна.
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын зохион байгуулалт: Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийг удирдлага болгон ТУЗ-ийн 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн №26/010 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх чиг үүргийн 4 хороог шинээр байгуулж, дарга болон гишүүдийг томиллоо. Үүнд:
 - Нэр дэвшүүлэх хороо: Дарга Г.Гантуяа (хараат бус), гишүүд О.Мөнхзул (хараат бус), П.Дэлгэрмаа (ердийн)
 - Цалин, урамшууллын хороо: Дарга О.Мөнхзул (хараат бус), гишүүд Б.Жавхланбаяр (хараат бус), Г.Хатанболд (ердийн)
 - Аудит, мэдээллийн аюулгүй байдлын хороо: Дарга О.Мөнхзул (хараат бус), гишүүд Г.Гантуяа (хараат бус), В.Болорчимэг (ердийн)
 - Бизнес хөгжлийн хороо: Дарга З.Төрболд (ердийн), гишүүд А.Баттамир (ердийн), Ч.Мөнхжаргал (ердийн). Хараат бус гишүүдээр хороодыг ахлуулсан нь ТУЗ-ийн шийдвэр гаргалт, хяналтын процессыг илүү хараат бус, мэргэжлийн түвшинд явуулах засаглалын давуу талыг бий болгож байна.
- Хувьцаа эзэмшигчдийн өгөөж: ТУЗ-ийн № 26/002 тоот тогтоолын дагуу 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 137,808,496 төгрөгийн ногдол ашгийг "ҮЦТХТ" ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэдээ амжилттай хуваарилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллав.





www.itools.mn



75755585



info@itools.mn